



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

ХХІХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын ХХІХ дүгээр хурал 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 10:00 цагт Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 87.5 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Т.Мөнхсайхан*

2. Бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд үе шаттайгаар шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний талаар;

*Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Л.Цэдэвсүрэн*

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах, соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх тухай;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян*

4. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбогдуулан газрын тосны ашиглалт, олборлолтыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Г.Ёндон

5. Татан авах иргэдийн нэрсийг баталгаажуулах технологийн шийдлийн талаар (Гэрэгэ системс);

Гадаад харилцааны яамны
Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн
Н.Анхбаяр

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
бригадын генерал Г.Ариунбуян нарт:

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилэн шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэхээр тогтов.

Хоёр. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт:

2.1. Сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын байгууллагууд, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;

Гурав. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

3.1. Тусгаарлан, ажиглах 21 хоногийн хугацааг хэвээр үлдээж, гэрийн тусгаарлалтын 14 хоногийн хугацааг цуцлах;

3.2. Тусгай үүргийн нислэгээр татан авах монгол иргэдийг коронавируст халдварын шинжилгээнд бүрэн хамруулах, тусгаарлан, ажиглах байр, шинжилгээний лабораторын хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлэх;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,
Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр нарт:

4.1. Гадаад орноос эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах үйл ажиллагааг эрчимжүүлж, 2020 оны 10 дугаар сараас эхлэн зарим орнууд руу

чиглэсэн хуваарьт нислэг үйлдэх асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран судлаж, санал боловсруулах;

Тав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон,
Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,
Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Ж.Болд,
Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,
Дорнод аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн,
Сүхбаатар аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга Ж.Эрдэнэбаатар нарт:

5.1. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших газрын тосны ашиглалтын Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайнуудад Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд оролцох БНХАУ-ын инженер техникийн ажилтан, мэргэжилтнүүдийг Монгол, Хятадын хилийн боомтын "Ногоон гарц"-ыг хэрэгжүүлэх түр журмын дагуу Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

5.2. Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ орд газруудын газрын тосны ашиглалт, олборлолтын тогтвортой ажиллагаа, батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийн орлогын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай тусгай зориулалтын автомашин техник, тоног төхөөрөмж, бараа материалыг БНХАУ-аас Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор нэвтрүүлж, импортын тээвэрлэлт гүйцэтгэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.3. Монгол Улсын хилийн боомтуудаар нэвтэрч байгаа зорчигч тээврийн хэрэгсэлд хийх хяналт шалгалтыг сайжруулж, холбогдох дүрэм журмыг шинэчлэх, халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлэх;

5.4. Хилээр нэвтэрч байгаа олон улсын ачаа тээвэр болон ТИР автомашины жолоочид тавих хяналтыг сайжруулах;

Зургаа. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,
Тагнуулын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа П.Одонбаатар,
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ нарт:

6.1. Гадаад харилцааны яам "Гэрэгэ системс" ХХК-тай хамтарсан уулзалт зохион байгуулж, хилийн чанадаас нутаг буцах хүсэлтэй монгол иргэдийг татан

авахтай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, иргэдийг нислэгт хамруулах ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилгоор цахим программ боловсруулж нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;


Долоо. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,
Аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;

7.1. Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж, бизнесийн үйл ажиллагааг дэмжих;

7.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг холбогдох заавар, зөвлөмжийн дагуу тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтмол зохион байгуулж, тусгайлан гаргасан дүрэм, журам, зааврыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран мөрдүүлэх, коронавируст цар тахлын талаарх мэдлэг, ойлголт, сургалт сурталчилгааны ажлыг чанартай зохион байгуулж, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;


7.3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Амны хаалтаа зүүцгээе" аяныг эрчимжүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА,
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА



Т.МӨНХДОРЖ